



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/13/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 51-261885 Цахим хаяг: serjmayadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Долгоржав
Утас: 51-261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: Ажу мэргэн Аудит ХХК
Захирал: Л.Насанбуян Утас: 7711-3008
Цахим хаяг: Ajumergenaudit.mon@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.1 Аудит хийсэн санхүү байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт	17
4.4 Зөвлөмж	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АГАДҮТ	Ажил гүйлгээний анги дансны үлдэгдэл, тодруулга
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
БЗС	Боловсролын зээлийн сан
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.БАЙГАЛСАЙХАН ТАНАА

2022 03.15 № 07/560
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатарын их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүү байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	748,679,435.50	1,208,974,992.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	277,977,985.66	565,055,950.19
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	277,977,985.66	565,055,950.19
3121	Төгрөг	277,977,985.66	565,055,950.19
31213	Арилжааны банк дахь харилцах	277,977,985.66	565,055,950.19
33	АВЛАГА	462,750,200.00	597,305,332.46
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	462,750,200.00	594,409,694.46
33201	Бусад авлага		2,895,638.00
34	УРЬДЧИЛГАА	-	33,667,500.00
34100	Урьдчилж гарсан зардал	-	33,667,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	7,951,249.84	12,946,209.84
351	Түүхий эд материал	-	-
354	Хангамжийн материал	7,951,249.84	12,946,209.84
35420	Аж ахуйн материал	7,951,249.84	12,946,209.84
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,631,959,444.23	7,494,743,180.53
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,631,959,444.23	7,494,743,180.53
392	Биет хөрөнгө	7,274,333,159.20	7,136,475,395.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,091,444,842.00	7,091,444,842.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(191,883,470.04)	(310,076,581.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	272,595,377.22	276,791,877.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(85,164,059.36)	(106,566,829.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	180,004,012.22	180,144,012.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	(132,097,938.50)	(138,281,850.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,665,000.18	19,665,000.18
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,282,191.52)	(5,580,082.12)
39217	Ном	124,051,587.00	128,935,007.00
393	Биет бус хөрөнгө	357,626,285.03	358,267,785.07
39301	Програм хангамж	12,615,000.00	14,475,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,490,874.97)	(3,709,374.93)
39303	Бусад биет бус хөрөнгө	347,502,160.00	347,502,160.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,380,638,879.73	8,703,718,173.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	134,296,670.23	413,576,102.77
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	134,296,670.23	413,576,102.77
413	Өглөг	41,627,546.00	97,432,045.46
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	28,176,225.06	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	647,246.00	-
4136	Бусад өглөг	12,804,074.94	97,432,045.46
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	12,804,074.94	97,432,045.46
414	Урьдчилж орсон орлого	92,669,124.23	316,144,057.31
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж	92,669,124.23	316,144,057.31
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,246,342,209.50	8,290,142,070.25
51	Засгийн газрын хувь оролцоо	8,246,342,209.50	8,290,142,070.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,352,370,591.00	2,352,370,591.00
51101	Өмч: - төрийн	2,352,370,591.00	2,352,370,591.00
512	Хуримтлагдсан үр дүн	187,744,931.29	231,544,792.04
51210	Өмнөх үеийн үр дүн	25,421,772.86	187,744,931.29
51220	Тайлант үеийн үр дүн	162,323,158.43	43,799,860.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,706,226,687.21	5,706,226,687.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,380,638,879.73	8,703,718,173.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,777,792,953.10	1,730,124,566.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,777,792,953.10	1,730,124,566.4
120	Нийтлэг татварын бус орлого	1,587,351,284.02	1,478,434,702.2
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,587,351,284.02	1,478,434,702.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,305,753,362.00	1,197,241,251.4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	281,597,922.02	281,193,450.82
121	Хөрөнгийн орлого	66,919,969.08	-
122	Тусламжийн орлого	123,521,700.00	3,478,420.00
122002	Хандив тусламж /гадаад/	123,521,700.00	3,478,420.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	248,211,444.20
	Бусад төсөвт байгууллагаас		248,211,444.20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,849,437,990.51	1,686,324,705.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,849,437,990.51	1,686,324,705.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,845,507,990.51	1,685,124,705.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	995,719,564.28	1,071,082,654.8
210101	Үндсэн цалин	995,719,564.28	1,071,082,654.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,119,612.67	119,621,288.67
210201	Тэтгэврийн даатгал	126,119,612.67	119,621,288.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,392,927.71	18,555,683.00
210301	Гэрэл, цахилгаан	17,981,728.00	16,419,763.00
210302	Түлш, халаалт	30,756,080.49	2,135,920.00
210303	Цэвэр, бохир ус	11,655,119.22	-
2104	Хангамж, бараа материалын зардал	14,604,986.36	16,132,095.10
210401	Бичиг хэрэг	733,700.00	963,818.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,441,736.36	13,433,177.10
210404	Ном, хэвлэл	1,769,550.00	1,735,100.00
210405	Харуул хамгаалалтын зардал	660,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,351,780.00	8,623,260.00
210604	Урсгал засвар	2,351,780.00	8,623,260.00
2107	Томилолт, зочны зардал	400,000.00	788,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	400,000.00	788,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,079,022.17	32,177,192.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,526,000.00	31,907,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	553,022.17	269,892.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	636,840,097.32	418,144,532.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	467,867,117.68	237,552,381.39
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,881,160.00	32,295,967.01
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	136,091,819.64	148,296,183.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,930,000.00	1,200,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,930,000.00	1,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(71,645,037.41)	43,799,860.75
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(71,645,037.41)	43,799,860.75

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,352,370,591.00	5,706,226,687.21	25,421,772.86	8,084,019,051.07
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00	00	00	00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,352,370,591.00	5,706,226,687.21	25,421,772.86	8,084,019,051.07
Тайлант үеийн үр дүн	-	-	162,323,158.43	162,323,158.43
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,352,370,591.00	5,706,226,687.21	187,744,931.29	8,246,342,209.50
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,352,370,591.00	5,706,226,687.21	187,744,931.29	8,246,342,209.50
Тайлант үеийн үр дүн	-	-	43,799,860.75	43,799,860.75
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,352,370,591.00	5,706,226,687.21	231,544,792.04	8,290,142,070.25

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,193,196,082.19	1,965,502,254.04
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
110	Орлогын албан татвар	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,109,643,929.19	1,650,490,809.84
120	Нийтлэг татварын бус орлого	1,109,643,929.19	1,650,490,809.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,109,643,929.19	1,650,490,809.84
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	821,793,655.13	1,243,245,505.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	287,850,274.06	407,245,304.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	83,552,153.00	315,011,444.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	83,552,153.00	315,011,444.20
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	83,552,153.00	315,011,444.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
1330	Төсвийн захирагчдаас	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,433,611,271.78	1,667,550,289.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,433,611,271.78	1,667,550,289.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,428,022,321.78	1,666,350,289.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	937,532,723.72	900,716,490.74
210101	Үндсэн цалин	937,532,723.72	900,716,490.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,318,170.64	247,229,699.65
210201	Тэтгэврийн даатгал	116,318,170.64	247,229,699.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,392,927.71	18,555,683.00
210301	Гэрэл, цахилгаан	17,981,728.00	16,419,763.00
210302	Түлш, халаалт	30,756,080.49	2,135,920.00
210303	Цэвэр, бохир ус	11,655,119.22	-
2104	Хангамж, бараа материалын зардал	14,274,986.36	17,498,381.57
210401	Бичиг хэрэг	733,700.00	963,818.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,441,736.36	14,799,463.57
210404	Ном, хэвлэл	1,769,550.00	1,735,100.00
210405	Зеелен эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	330,000.00	-
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,351,780.00	8,187,760.00
210604	Урсгал засвар	2,351,780.00	8,187,760.00
2107	Томилолт, зочны зардал	400,000.00	961,978.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	400,000.00	961,978.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,247,622.17	59,919,502.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,651,000.00	38,024,190.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	553,022.17	269,892.03
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,043,600.00	21,625,420.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	270,504,111.18	413,280,794.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	238,521,799.18	373,915,067.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,982,312.00	39,365,726.54
211	ХҮҮ	-	-
212	ТАТААС	-	-

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,588,950.00	1,200,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,588,950.00	1,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,588,950.00	1,200,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(240,415,189.59)	297,951,964.53
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,482,690.00	10,874,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,482,690.00	10,874,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,482,690.00	10,874,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,482,690.00	10,874,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,482,690.00)	(10,874,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(245,897,879.59)	287,077,964.53
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	523,875,865.25	277,977,985.66
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	277,977,985.66	565,055,950.19

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I.Нийт орлогын дүн		1,777,792,952.	1,811,586,000.0	1,730,124,566.4	81,461,433.52	95.5
1.1	Үндсэн үйл ажиллагааны орлого	1,777,792,952.6	1,484,086,000.0	1,448,931,115.6	35,154,884.34	97.6
1.1.1	Төсвийн санхүүжилт	190,441,669.08	31,500,000.00	70,278,420.00	(38,778,420.00)	
	ЭШ-ний төсөл, хөтөлбөр	66,919,969.08		66,800,000.00	119,969.08	-
	Хандив тусламжийн орлого	123,521,700.00		3,478,420.00	(3,478,420.00)	-
1.1.2	Сургалтын төлбөрийн орлого	1,305,753,400.00	1,452,586,000.00	1,378,652,695.66	73,933,304.34	94.9
	Бакалаврын сургалтын	942,702,700.00	1,052,190,000.00	885,531,674.20	166,658,325.80	84.2
	Магистрын сургалтын	281,597,900.00	283,513,000.00	250,379,478.00	33,133,522.00	88.3
	Докторын сургалтын	31,452,800.00	30,528,000.00	37,190,690.00	(6,662,690.00)	121.8
	Гадаад оюутны	50,000,000.0	86,355,000.00	205,550,853.46	(119,195,853.46)	238.0
1.1.3	Үйл ажиллагааны бус орлого	281,597,883.52	327,500,000.00	281,193,450.82	46,306,549.18	85.9
	ЭШ-ний гэрээт ажил, төслийн орлого	221,881,291.87	250,000,000.00	229,238,705.00	20,761,295.00	91.7
	Харилцахын хүүгийн орлого	3,444,068.04	7,500,000.00		7,500,000.00	-
	Хураамж, бусад	56,272,523.61	70,000,000.00	51,954,745.82	18,045,254.18	74.2
II ЗАРЛАГЫН ДҮН		1,615,469,794.17	1,811,586,000.0	1,579,151,273.44	232,434,726.56	87.2
2.1	Цалин хөлсний зардал	1,093,516,153.95	1,099,919,500.0	1,190,703,943.50	(90,784,443.50)	108.3
	Цалин хөлс. нэмэгдэл урамшуулал	967,864,564.28	1,009,759,500.0	1,071,082,654.83	(61,323,154.83)	106.1
	НДШ	125,651,589.67	90,160,000.00	119,621,288.67	(29,461,288.67)	132.7
2.2	Бараа үйлчилгээний нийтлэг зардал	42,945,738.53	144,450,000.00	76,845,420.64	67,604,579.36	53.2
	Бичиг хэргийн зардал /захиргаа/	733,700.00	3,000,000.00	963,818.00	2,036,182.00	32.1
	Аж ахуйн зардал	3,245,212.17	6,500,000.00	4,211,422.03	2,288,577.97	64.8
	Шуудан холбооны зардал	2,941,496.36	3,850,000.00	3,820,287.61	29,712.39	99.2
	Шагналын зардал	4,113,950.00	5,000,000.00	4,754,320.00	245,680.00	95.1
	Гадаад арга хэмжээний зардал	400,000.00	2,000,000.00		2,000,000.00	-
	Тусламж тэтгэлэгийн	3,930,000.00	6,000,000.00	1,380,000.00	4,620,000.00	23.0

	зардал					
	Урсгал засварын зардал	2,351,780.00	45,000,000.00	8,623,260.00	36,376,740.00	19.2
	Төлбөр хураамжийн зардал	8,526,000.00	35,000,000.00	31,907,300.00	3,092,700.00	91.2
	Хэвлэл мэдээлэлийн зардал	16,043,600.00	35,100,000.00	19,500,000.00	15,600,000.00	55.6
	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зардал	660000.00	3,000,000.00	1,685,013.00	1,314,987.00	56.2
2.3	Сургалтын үйлчилгээний зардал	56,692,260.00	92,000,000.00	49,617,956.50	42,382,043.50	53.9
	Тогтмол хэвлэлийн зардал	1,769,550.00	4,000,000.00	1,735,100.00	2,264,900.00	43.4
	Хичээл практикийн зардал	36,886,160.00	45,000,000.00	32,295,967.01	12,704,032.99	71.8
	Интернэтийн зардал	8,500,000.00	10,000,000.00	9,612,889.49	387,110.51	96.1
	Оюутны үйлчилгээний зардал	735,000.00	9,000,000.00	600,000.00	8,400,000.00	6.7
	Уралдаан тэмцээний зардал	3,582,100.00	6,000,000.00	3,374,000.00	2,626,000.00	56.2
	Мэргэжлийн олимпиадын зардал		2,000,000.00		2,000,000.00	-
	Гадаад багшийн		1,000,000.00		1,000,000.00	-
	Багшийг дэмжих ҮА-ны	5,219,450.00	15,000,000.00	2,000,000.00	13,000,000.00	13.3
2.4	Эрдэм шинжилгээ. инновацийн	232,918,023.98	257,500,000.00	232,348,349.80	25,151,650.20	90.2
	Эрдэм шинжилгээ	231,458,023.98	250,000,000.00	229,828,349.80	20,171,650.20	91.9
	Удирдах зөвлөлийн	1,460,000.00	7,500,000.00	2,520,000.00	4,980,000.00	33.6
2.5	Тогтмол зардал	60,392,927.71	74,758,300.00	18,555,683.00	56,202,617.00	24.8
	Гэрэл цахилгаан	17,981,728.00	20,000,000.00	16,419,763.00	3,580,237.00	82.1
	Халаалтын зардал	30,756,080.49	38,758,300.00	2,135,920.00	36,622,380.00	5.5
	Цэвэр бохир усны зардал	11,655,119.22	16,000,000.00		16,000,000.00	-
2.6	Хөрөнгийн зардал	129,004,690.00	167,729,500.00	11,079,920.00	156,649,580.0	6.6
	ТТ худалдан авах зардал	112,033,600.00	80,000,000.00	4,196,500.00	75,803,500.00	5.2
	Тавилга эд хогшил худалдан авах зардал	723,690.00	53,729,500.00	140,000.00	53,589,500.00	0.3
	Программ хангамж	10,945,000.00	24,000,000.00	1,860,000.00	22,140,000.00	7.8
	Ном сурах бичгийн зардал	5,302,400.00	10,000,000.00	4,883,420.00	5,116,580.00	48.8
	Ном сурах бичгийн	5,302,400.00	8,000,000.00	4,883,420.00	3,116,580.00	61.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөжөөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад программын сайжруулалт хийлгэх, түрээсийн гэрээний нөхцөл шинэчлэх, татварын тайланг үнэн зөв тайлагнахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 12-ноос 2022 оны 03 дугаар сарын 11-ний хооронд “Ажуу мэргэн аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал Л.Насанбуян, аудитор Д.Наранчимэг, туслах аудитор Д.Шандбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Л.Долгорсүрэн хэрэгжүүлсэн.

Улаанбаатарын их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/026 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улаанбаатарын их сургуулийн дүрэмд тус сургуулийн эрхэм зорилго нь “Эрдэмтэн багш нарын нөөц бололцоо, сургалтын баазад түшиглэн шинжлэх ухаан үйлдвэрлэл, нийгмийн бүхий л салбарт бие даан ажиллах чадвартай, хувь хүний хөгжил, харилцааны өндөр соёлтой мэргэжлийн боловсон хүчнийг өөрийн болон өндөр хөгжилтэй орнуудын жишигт нийцүүлэн бэлтгэх, сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогц бодлого бүхий сургуулийн үйл ажиллагааг тасралтгүй хөгжүүлэхэд оршино” гэсэн байна.

Мөн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын үйл ажиллагаа явуулах
- Монгол судлалын шинжлэх ухааны салбарын эрдэмтэн судлаач бэлтгэх
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрхлэн явуулах,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Улаанбаатарын их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж дээд боловсролын удирдлага мэдээллийн системд оруулж байгаа статистик

мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв оруулж байх, хөрөнгийн орлого, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, эрдэм шинжилгээний зардлын зарцуулалтад нягтлан бодогчийн зүгээс тавих хяналтыг сайжруулах гэсэн зөвлөмжүүдийг өгсөн байна.

Дотоод аудитаас өгсөн зөвлөмж, зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайлангаар сургуулийн бүртгэл тайлангийн талаар боломжит хэмжээний ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын сайдын 2019 оны А/737 тоот тушаалаар төрийн өмчит, их сургуульд мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан боловч энэ нь эцэслэн батлагдаагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Улаанбаатарын их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын судалгаа хийж, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын сууриар нийт орлогын үзүүлэлтийг сонгов. Материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,777.7 сая төгрөгний 1,0 хувиар болох 17.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тооцох суурь үзүүлэлт, эрсдэлийн үнэлгээ өөрчлөгдөөгүй тул төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаанбаатарын их сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 323.0 сая төгрөгөөр нэмэгдсэн. Материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, урьдчилж төлсөн тооцоо, өглөг, эздийн өмчийн дансдуудыг өсөлт байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	277,977.9	565,055.9	287,078.0
Авлага	462,750.2	597,305.3	134,555.1
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	-	33,667.5	33,667.5
Бараа материал	7,951.2	12,946.2	4,995.0
Үндсэн хөрөнгө	7,631,959.4	7,494,743.2	(137,216.2)
Богино хугацаат өглөг	134,296.7	413,576.1	279,279.4
Цэвэр хөрөнгө, өмчийн дүн	8,246,342.2	8,290,142.0	43,799.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,380,638.9	8,703,718.2	323,079.3

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 565.0 сая төгрөг болж 287.1 сая төгрөгөөр өссөн, Худалдаа хөгжлийн, ХААН, Голомт, Капитрон банканд харилцах данстай, үүнээс Худалдаа хөгжлийн банканд 330.1 сая төгрөг, ХААН банканд 228.6 сая төгрөг бусад банканд 6.3 сая төгрөг байршиж байгаа ба Covid-19 цар тахалтай холбоотой шалтгаанаар тайлант онд харилцах дансны үлдэгдэлд хүү бодож олгоогүй байна.

БШУС-ын өгсөн чиглэлийн дагуу оюутны сургалтын төлбөрийг үе шаттай хувааж авснаар өмнөх оноос авлага 134.5 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Урьдчилж гарсан зардал дансанд эрдэм шинжилгээний номын орчуулга хийлгэх ажлын төлбөрт 33.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй.

Бараа материалын дансны үлдэгдэл 12.9 сая төгрөг болж, 4.9 сая төгрөгөөр өссөн нь сургалтанд ашиглах номын фонд, эрдэм шинжилгээний ажлын ном хэвлэгдэн гарч нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс худалдан авсан хөрөнгө 11.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, тайлант оны элэгдлийн зардал 148.4 сая төгрөг байна.

Богино хугацаат өр төлбөр 413.5 сая төгрөгөөс сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого 316.1 сая төгрөг, ХХОАТ-ын өр 97.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй.

3.6 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 “Төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох 20 дугаар зүйлийн 1.3 “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн захирал нь байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй

Улаанбаатарын их сургуулийн Удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 02 тоот тогтоолоор “2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 1,811.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,811.5 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтыг 167.7 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний ашиг алдагдлыг Ковид-19 цар, тахлын үеийн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан үйл ажиллагааны орлого болон зарлагыг тооцож, давсан орлогоороо хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 1,730.1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн нь төлөвлөгөөнөөс 81.5 сая төгрөг буюу 4.5 хувиар буурсан, үүнээс сургалтын төлбөрийн орлого 1,378.6 сая төгрөг байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,579.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 232.4 сая төгрөг буюу 12.8 хувиар дутуу зарцуулсан нь бараа үйлчилгээний нийтлэг зардалд 67.6 сая, сургалтын үйлчилгээнд 42.4 сая, эрдэм шинжилгээ, инновацид 25.2 сая, хичээл практикт 12.7 сая, урсгал засварт 36.4 сая, хэвлэл мэдээлэлд 15.6 сая, эрдэм шинжилгээнд 20.2 сая, тогтмол зардал 56.2 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулсан нь танхимын сургалтыг цахим сургалтанд шилжүүлэн, эрдэм шинжилгээ, сургалт, дадлагын ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээнд 11.1 сая төгрөгийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс санхүүжүүлж худалдан авсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь 8 алба, эрдэм шинжилгээ, судалгааны 2 хүрээлэн, багшийн хөгжлийн төв, сургалтын мэргэжлийн 10 тэнхим, гадаад хэлний 3 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Удирдлага үндсэн үйл ажиллагааны хүрээнд хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 35 арга хэмжээ хэрэгжүүлсэнийг тус сургуулийн Удирдах зөвлөлийн тогтоолоор 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг “хангалттай” гэж дүгнэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

БШУС-ын түр журам шинэчлэн тогтоох тухай А/135 тоот тушаал, захирлын тушаалыг үндэслэн бакалаврын шинэ элсэгчдэд зориулан тэтгэлэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг 46 оюутанд 18.3 сая, магистрын ангийн гадаадын 10 оюутан, дотоодын 6 оюутанд 51,3 сая нийт 69.6 сая төгрөгийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улаанбаатарын их сургууль нь Шилэн дансны цахим хуудсанд 6 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, ажил гүйлгээний 11 мэдээлэл, худалдан авах ажиллагаа, зорилтот түвшний хэтрэлт хэмнэлтийн тайланг байршуулаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага өгөх

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Захирлын 2021 оны Б/41 тоот тушаалаар багш ажилтнуудын цалин нэмж цалин, НДШ-ийн зардлыг батлагдсан төсвөөс 90.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын 1.2 шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан

тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 152.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 147.5 сая төгрөгийг залруулж, ээлжийн амралтын илүү тооцсон 2.0 сая төгрөгийн зөрчлийн төлбөрийг барагдуулж, биелэлт 97.3 хувь байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 8.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 22.4 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс төлбөрийн актын биелэлт хэрэгжээгүй, албан шаардлага 100 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/ сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	2.9			1	2.9	50
Албан шаардлага	2	8.7	2	8.7			100
Зөвлөмж	2	22.4	2	22.4			100
Нийт дүн	5	34.0		31.1	1	2.9	91.5

Өмнөх оны аудитаар хувь хүний дансанд шилжүүлсэн НДШ-ийн бүруутай ажилтанаар нийгмийн даатгалын байгууллагад төлүүлэх төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй, тухайн төлбөрийг эрдэм шинжилгээний зардалд бүртгэж нийгмийн даатгалын байгууллагад төлсөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй.

3.12 Анхаарал татсан асуудал

Татварын албаны цахим систем буюу татварын тодорхойлолтоор тус сургуулийн цалин хөлс ба түүнтэй адилтгах орлогоос суутгасан татварын эхний үлдэгдэл 100.4 сая төгрөгөөр илүү төлөлттэй, буруу мэдээлэгдэж байгаагаас тухайн жилд төсөвт төлөх төлбөрийг төлөөгүй, татварын өрийг нэмэгдүүлсэн байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 281.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 267.7 сая төгрөгийн алдааг залруулж, 6,1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 3.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа зөрчлийн дүн 13.8 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 17.8 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:·

- Ажлын гүйцэтгэл нь гараагүй 26.9 сая төгрөгийн ажил гүйлгээг эрдэм шинжилгээний зардалд бүртгэж тайлант хугацааны үр дүнг бууруулсан;
- Оршин суугч бус иргэнд олгосон орлогоос суутгасан 6.7 сая төгрөгийн татварыг өглөг үүсгэж бүртгээгүй, татварт төлөх үлдэгдлийг буруу илэрхийлсэн;
- Сургалтын орлогыг аккруэл сууриар бүртгээгүйгээс 140.3 сая төгрөгөөр авлагын дүн, тайлант хугацааны үр дүнг буруу илэрхийлсэн;
- Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар 90.7 сая төгрөгийн өглөгийн санхүүгийн тайланд буруу бүртгэсэн;
- Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоосон 2.9 сая төгрөгийн авлага бүртгээгүй байсан байна.

4.2 Төлбөрийн акт

Шинжлэх ухааны байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж 6.1 сая төгрөгийн хандив бэлэг дурсгалын зүйл өгсөн байна.

Энэ нь Засгийн газрын төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын 1.3 "...төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй, төлбөрийг буруутай ажилтанаар төлүүлж төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны Ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5 гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага өгөх

2. Иргэнтэй 2021 оны 10 сард сургуулийн цайны газарт үйл ажиллагаа явуулах байр ашиглах гэрээнд түрээсийн төлбөр тусгаагүй ус цахилгааны төлбөрийг тоолуурын заалтаар төлөхөөр байгуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх" журмын 2.13 заалт Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг байгуулахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварыг үндэс болгоно. ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Программ хангамжтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Одоогийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн программ нь суралцагчдын сургалтын төлбөрийн орлого, авлагын дэлгэрэнгүйг оюутан бүрээр хөтөлж тайлагнахад шаардлага хангахгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 47 тоот тушаалын 1-р хавсралт “Аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж:

Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн, хөрвөх боломжтой санхүүгийн программ хангамжийг НББ-дээ ашиглах

2. Татварын тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын тайланд тайлагнасан цалингийн дүн, цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын тайлан дахь цалингийн дүнг 38,3 сая төгрөгөөр дутуу тайлагнаснаас татварын өглөгийг 3.4 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1 Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1. олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, татварын албанд хүсэлт явуулж тайланг залруулж тайлагнах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/														
Д/ д	Байгуул агын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа зөрчил		Үүнээс:							
							Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					То о	Дүн	То о	Дүн	То о	Дүн	То о	Дүн	То о	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	УБИС	АХГ- 2022/13/Н А-СТА- ТӨА	Гэрээний дагуу урьдчилж олгосон орчуулгын ажлын төлбөр 26.9 сая төгрөгийг зардалд хүлээн зөвшөөрч бүртгэж тайлант хугацааны үр дүнг бууруулсан	Эрдэм шинжилгээний зардлыг бууруулж урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэж залруулсан.	1	26,934.0	1	26,934.0						
2	УБИС	АХГ- 2022/13/Н А-СТА- ТӨА	Гэрээний дагуу иргэн Байгал /оршин суугч бус/-д олгосон урьдчилгаа төлбөрөөс суутгасан 6.7 сая төгрөгийн ХХОАТ-ыг татварын албанд ТТ-2 маягтаар тайлагнасан боловч санхүүгийн тайланд өглөг үүсгэж бүртгээгүй байна	ХХОАТ-ын өглөг үүсгэж урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэж залруулсан	1	6,733.5	1	6,733.5						
3	УБИС	АХГ- 2022/13/Н А-СТА- ТӨА	Байгууллага нь сургалтын орлогыг аккрузал сууриар бүртгээгүйгээс 140.4 сая төгрөгийг санхүүгийн тайланд дутуу бүртгэж орлого үр дүн, авлагын дүнг буруу тайлагнасан байна.	Сургалтын орлого бүртгэж авлага үүсгэж залруулсан	1	140,412.2	1	140,412.2						
4	УБИС	АХГ- 2022/13/Н А-СТА- ТӨА	Цалин хөлс ба түүнтэй адилтгах орлогын татварын өглөг 90,6 сая төгрөгийг авлагын дансанд хааж бүртгэсэн	Татварын өглөг үүсгэж авлага өсгөж бүртгэсэн	1	90,698.5	1	90,698.5						
5	УБИС	АХГ- 2022/13/Н А-СТА- ТӨА	Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актыг биелэлтийг хангаж ажиллаагүй, тогтоосон төлбөрийг буруутай ажилтанаар төлүүлэхээр авлага үүсгэж бүртгээгүй байна.	Өмнөх жилийн аудитаар тогтоосон төлбөрийн актыг биелэлтийн биелэлт хангаагүй тул төлбөрийн акт тогтоох	1	2,895.6			1	2,895.6				
6	УБИС	АХГ- 2022/13/Н А-СТА- ТӨА	Монгол Улсын Шинжлэх ухааны байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж хандив өгсөн байна	Төлбөрийн акт тогтоох	1	6,071.5			1	6,071.5				
7	УБИС	АХГ- 2022/13/Н А-СТА- ТӨА	Нийгмийн даатгалд тайлагнасан цалингийн дүн нь цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварт тайлагнасан цалингийн дүнгээс 38,3 сая төгрөгөөр дутуу тайлагнаж татварын өрийг 3,4 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн.	Татварын тайланг үнэн зөв хийж байх зөвлөмж өгөх	1	3,389.9							1	3,389.9

Улаанбаатарын их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

8	УБИС	АХГ-2022/13/Н А-СТА-ТӨА	Иргэнтэй 2021 оны 10 сард сургуулийн цайны газарт үйл ажиллагаа явуулах байр ашиглах гэрээнд түрээсийн төлбөр тусгаагүй ус цахилгааны төлбөрийг тоолуурын заалтаар төлөхөөр байгуулсан байна.	Түрээсийн гэрээ хийх, орлого нэмэгдүүлэх зөвлөмж өгөх	1	1,427.2					1	1,427.2		
9	УБИС	АХГ-2022/13/Н А-СТА-ТӨА	Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй байна.	Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага	1	2,895.6					1	2,895.6		
10	УБИС	АХГ-2022/13/Н А-СТА-ТӨА	Одоогийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн програм нь суралцагчдын сургалтын төлбөрийн орлого, авлагын дэлгэрэнгүйг оюутан бүрээр хөтөлж тайлагнахад шаардлага хангахгүй байна.	Санхүүгийн програм хангамжийг сайжруулах зөвлөмж өгөх	1								1	
НИЙТ ДҮН					10	281,458.0	5	267,673.8	1	6,071.5	2	4,322.8	2	3,389.9
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	УБИС	АХГ-2022/13/Н А-СТА-ТӨА	Шилэн дансанд 6 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 11 мэдээлэл, тайлант оны худалдан авах ажиллагааны тайлан, зорилтот түвшний хэтрэлт хэмнэлтийн тайланг байршуулаагүй	Өмнө жилийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй тул хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.	1						1			
2	УБИС	АХГ-2022/13/Н А-СТА-ТӨА	Цалингийн зардлыг төлөвлөсөн дүнгээс 90.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн	Засгийн газрын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага өгсөн	1	90,784.4					1	90,784.4		
НИЙТ ДҮН					2	-	0	-	0	-	2	-	0	-
НИЙТ ДҮН					12	372,242.4	5	267,673.8	1	6,071.5	4	95,107.2	2	3,389.9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 74/АД/50058

Улаанбаатар хот

АХГ-2022/13/НА-СТР-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинжлэх ухааны байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж 6,071,460.00 төгрөгийн хандив, бэлэг дурсгалын зүйл өгсөн байна.

Энэ нь Засгийн газрын төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын 1.3. "...төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ойн арга хэмжээнд зориулж хандив, бэлэг дурсгалын зүйл өгсөн 6,071,460.0 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатарын их сургуулийн захирал С.Байгалсайхан, нягтлан бодогч О.Туяа нарт даалгав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭГГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264330

9006109
9019120396

\\10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0315 Auditin 4 Gazar-11.Docx

001090219



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 335/20150058

Улаанбаатар хот

АХГ- 2022/13/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Иргэнтэй 2021 оны 10 сард сургуулийн цайны газарт үйл ажиллагаа явуулах байр ашиглах гэрээнд, түрээсийн төлбөр тусгаагүй ус цахилгааны төлбөрийг тоолуурын заалтаар төлөхөөр байгуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх" журмын 2.13 заалт Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг байгуулахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварыг үндэс болгоно. ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цайны газрыг түрээслүүлэх гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатарын их сургуулийн захирал С.Байгалсайхан, нягтлан бодогч О.Туяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Л.НАСАНБУЯН

0010801115



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 394/20150058
АХГ-2022/13/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захирлын 2021 оны Б/41 дүгээр тушаалаар багш ажилтнуудын цалинг нэмж цалин, НДШ-ийн зардлыг батлагдсан төсвөөс 90,784,443.00 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын 1.2 шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатарын их сургуулийн Захирал С.Байгалсайхан, нягтлан бодогч О.Туяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Л.НАСАНБУЯН

0010801113



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 393/20150058

Улаанбаатар хот

АХГ- 2022/13/НА- СТА ТӨА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2,895,638.00 төгрөгийн төлбөрийн актыг буруутай ажилтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлээгүй, байна.

Энэ нь Захиргааны Ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5 гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар төлбөрийн акт тогтоосон, буруутай ажилтнаар төлүүлэх 2,895,638.00 төгрөгийг төлүүлж авлагыг барагдуулах;
2. Төрийн аудитын байгууллагаас тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй Д.Эрдэнэбаатард хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатарын их сургуулийн захирал С.Байгалсайханд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ийн АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Л.НАСАНБУЯН



0010801111



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 391/20150058

Улаанбаатар хот

АХГ-2022/13/МА-СТД ТӨА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 6 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, ажил гүйлгээний 11 мэдээлэл, худалдан авах ажиллагаа, зорилтот түвшний хэтрэлт, хэмнэлтийн тайланг байршуулаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй,

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1 "мэдээлэл үнэн зөв бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй нягтлан бодогч О.Туяад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатарын их сургуулийн захирал С.Байгалсайханд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Л.НАСАНБУЯН

9006109
9019120396

0010801109

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

[illegible]

[illegible]